



БАЯНХОНГОР АЙМАГ  
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар A/92

Баянсайр

Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр  
2022 онд хэрэгжүүлэх төслийн эрэмбэлэгдсэн  
жагсаалт санхүүжилт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-ын 43.2.1, Хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралт “Хоршоог хөгжүүлэх сан”-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шлгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дахь хэсгийн 3.4-ын 3.4.2, 6 дэх хэсгийн 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумд үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн хөгжлийг хангах, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрийг үндэслэн 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн эрэмбэлэгдсэн жагсаалт, санхүүжилтийг хавсралтаар баталсугай.

2. Сангийн хөрөнгийг зориулатын дагуу үр ашигтай зарцуулж зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, үйл ажиллагааны үр дүнг тайлagnаж ажиллахыг төсөл хэрэгжүүлж байгаа хоршооны дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга (Б.Гэрэлмөнх), нягтлан бодогч (Д.Должинсүрэн)-д тус тус даалгасугай.



642101459

Сумын Засаг даргын 2022 оны  
08 дугаар сарын 22-ны өдрийн 11:00  
дугаар захирамжийн хавсралт

**ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН"-ГИЙН ХӨРӨНГӨӨР  
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЭРЭМБЭЛЭГДСЭН  
ЖАГСААЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ**

Эрэмбэ	Төсөл хэрэгжүүлэх хоршоо, төслийн нэр	Төслийн үйл ажиллагааны чиглэл	Санхүүжилтийн хэмжээ /сая . төг/
1	2	3	4
1	“Гэрэлт мөнх ундарга” хоршоо “Хөдөө аж ахуйн бирж” төсөл	Төмс, хүнсний ногоо тариалалт, мах, сүү, цагаан идээ, арьс шир, ноос ноолуур борлуулах	45
2	“Буянт таван буурал” хоршоо “Нутгийн цагаан идээ” төсөл	Сүү цагаан идээ боловсруулах, ээзгий, ааруул, шар тос, ерөм савлах, бэлгийн багц, тасгийн багц бэлтгэх	45
3	“Цанхир хайрхан” хоршоо “Буянт малын шим” төсөл	Хонини нэхий, ямааны болон хурга ишигний арьс бэлтгэх, сур, хөхүүр хийх, гэрийн хошлон бурантаг томох	35
4	“Бөөнцагаан” хоршоо “Эсгий үйлдвэрлэл” төсөл	Эсгий үйлдвэрлэх	28
ДҮН			153

ооо